



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/08

Чойр

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнө нь газраа өмчилж авсан иргэний газрын хаяг, хэмжээ нь мэргэжлийн байгууллагаар суурин газрын кадастрын зургийг хийхэд өөрчлөгдсөн тул хавсралтанд заагдсан иргэнийн өмчлөлийн газрын байршил, хэмжээ, хаягийг өөрчлөн өмчлүүлсүгэй.

2.Өмчилж авсан газраа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусдын өмчлөлд шилжүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тохиолдолд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байхыг хавсралтанд заагдсан иргэдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сүмбэр сумын Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг) нарт үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны А/73 дугаар захирамжийн хавсралтын 150, 151 дүгээр бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2022 оны 0.1. дүгээр сарын
11-ны өдрийн 4/10 дугаар захирамжийн хавсралт

Газар өмчлөх шийдвэрт өөрчлөлт орсон иргэдийн жагсаалт

д/д	Өмчлөх шийдвэрт өөрчлөлт орсон иргэдийн		Өмчлүүлэх газрын						
	Ургын овог, эцэг, эх, өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Өмнөх газрын хэмжээ /м ² /	Өөрчлөгдсөн газрын хэмжээ /м ² /	Өмнөх газрын хаяг, байршил	Өөрчлөгдсөн газрын хаяг, байршил	Үнэлгээ /мян.төг/	Өмнөх захирамжийг хүчингүй болгох хэсэг
1	Тайж нар овогт Түмэндэмбэрэлийн Гантулга	ФБ72101511	Гэр бүлийн хэрэгцээ	2000	1500	2-р баг Релей-1 гудамжны 1 тоот	2-р баг Шивээ-2 гудамжны 201 тоот	4500.0	Аймгийн Засаг даргын 2005 оны А/73 дугаар захирамжны хавсралтын 150 дугаар бүртгэл
	Тавьт овогт Хөхөөгийн Энхтөр	ФМ74012706							
	Тайж нар овогт Гантулгын Түмэнсайхан	ФА02281806							
	Тайж нар овогт Гантулгын Шинэсарнай	ФБ96092526							
2	Тайж нар овогт Дэмбэрэлийн Энхтуул	ФБ76102015	Гэр бүлийн хэрэгцээ	2000	1200	2-р баг Релей 1 гудамжны 2 тоот	2-р баг Шивээ-2 гудамжны 203 тоот	3600.0	Аймгийн Засаг даргын 2005 оны А/73 дугаар захирамжны хавсралтын 151 дүгээр бүртгэл